МЭДЭЭ · 2021 оны 6-р сарын 7

ЭРҮҮГИЙН 329 ХЭРЭГТ ЯЛЛАХ ДҮГНЭЛТ ҮЙЛДЭН ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага 2021 оны 5 дугаар сарын 31-нээс 6 дугаар сарын 04-ний өдрүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос гаргасан 202 гомдол, хүсэлтийг шийдвэрлэж, мөрдөгч болон зөрчлийн хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтанд тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр 297 даалгавар бичгээр өгсөн байна.

Гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар байгууллага, албан тушаалтанд 23 мэдэгдэл, зөрчил шалган шийдвэрлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх явцад гарсан зөрчил, түүнд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар хяналтын харьяа байгууллагуудад 8 шаардлага тус тус бичиж хүргүүлжээ.

Өнгөрсөн долоо хоногт 2070 хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьж, 329 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2534